



ТАМИРЧДАД ЗОРИУЛСАН ОЛОН УЛСЫН СЭРГЭЭШИЙН ЭСРЭГ 2015 ХУУЛИЙН ЛАВЛАГААНЫ УДИРДАМЖ



**WORLD
ANTI-DOPING
AGENCY**
play true



**Regional
Anti-Doping
Organization
of
Central
Asia**

R A D O C A



АГУУЛГА

1 ХЭСЭГ. АШИГТАЙ МЭДЭЭЛЭЛ	4
2 ХЭСЭГ. ХУУЛЬ	4
3 ХЭСЭГ. ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХ	6
4 ХЭСЭГ. ҮҮРГҮҮД	6
5 ХЭСЭГ. СЭРГЭЭШ ГЭЖ ЮУ ВЭ ?	7
6 ХЭСЭГ. ХОРИОТОЙ ЖАГСААЛТ	13
7 ХЭСЭГ. ЭМЧИЛГЭЭНД АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ	15
8 ХЭСЭГ. ДЭЭЖИЙН ШИНЖИЛГЭЭ, ЦУГЛУУЛГА, СОРИЛ	16
9 ХЭСЭГ. СЭРГЭЭШИЙН ЭСРЭГ ДҮРМИЙГ ЗӨРЧИХӨД ҮҮСЭХ ҮР ДАГАВАР	19
10 ХЭСЭГ. ИРЭЭДҮЙ РҮҮ ЭРГЭН ОЧИХ	23
1 ХАВСРАЛТ. СЭРГЭЭШ-ХЯНАЛТЫН ЖУРАМ	25
2 ХАВСРАЛТ. ДЭЭЖИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЖУРАМ	30

Олон улсын сэргээшийн эсрэг хуулийн зорилго нь тамирчдын эрхийг шударгаар хамгаалах явдал юм.

1-р ХЭСЭГ. АШИГТАЙ МЭДЭЭЛЭЛ

Олон улсын сэргээшийн эсрэг Хууль нь тамирчин Таны мөрдөх ёстой дүрмийг тогтоодог.

Энэхүү лавлагааны удирдамжийн зорилго нь: Танд тухайн дүрмийг ойлгоход туслах явдал.

Тухайн баримт бичиг нь зөвхөн удирдамж юм. Энэ нь Хуулийн нэр томьёог орлохгүй.

Хуулийн нэр томьёо нь анхны эх сурвалж гэдгийг анхаарвал зохино. Тухайн удирдамж нь зөвхөн Хуулийг ойлгоход туслах бөгөөд зайлшгүй хуулийн баримт бичиг биш.

Хуулийн эхний хэдэн хуудсан дээр “спортын оюун санаа”-ны үнэт зүйлийн тухай яригддаг. Зөвхөн энэ оюун санаа л аливаа сэргээшийн эсрэг үзэл санааг бий болгодог : (үгүй болгох, арилгах) Өөрөөр хэлбэл хориотой бодисыг санаатайгаар эсвэл санаатай бус ашиглах явдалыг арилгах, эсвэл хориотой аргыг арилгах, эсвэл сэргээшийн эсрэг дүрмийн бусад зөрчил гаргахгүй байх г.м

2-р ХЭСЭГ. ХУУЛЬ

Олон улсын Сэргээшийн эсрэг Хууль гэж юу вэ ?

Хууль нь сэргээшийн эсрэг системийн үндэс юм. Тухайн Хуулийг Олимпын хөдөлгөөн, дэлхий дахины янз бүрийн спортын байгууллага болон үндэсний сэргээшийн эсрэг байгууллагууд баталсан. Спортод сэргээштэй тэмцэх тухай ЮНЕСКО-гийн Олон улсын Конвенциэр дамжуулан 170 шахам орны Засгийн газар хүлээн зөвшөөрсөн.

Тухайн Хууль нь анх 2004 оны 07-р сард хүчин төгөлдөр болсон. Өөрчилөлт орсон Хуулийн анхны эх нь 2009 оны 01-р сарын 01-нд, хоёрдахь нь 2015 оны 01-р сарын 01-нд тус тус хүчин төгөлдөр болсон. Хуулийг бүрэн эхээр нь Олон улсын Сэргээшийн эсрэг агентлагийн сайтаас үзэж, танилцаж болно.

ОУСЭА (Олон улсын Сэргээшийн эсрэг агентлаг) хуулийг дэмжин техникийн болон журмын “Олон улсын стандартууд” боловсруулсан, Үүнд: Хориотой бодис болон хориотой аргын жагсаалт, Сорилын болон судалгааны Стандарт, эмчилгээнд хэрэглэх Стандарт, Лабораторт зориулагдсан Стандарт болон Хувийн амьдрал болон хувь хүний мэдээллийг хамгаалах Стандарт г.м

Тухайн удирдамжийн “Хэсэгт” иш татсан зүйл нь Хуулийн хэсэгт хамаарна, бусад баримт бичигт, жишээлбэл “Олон улсын Стандартууд”-д иш татсан зүйлс нь тусгайлан бичигдэнэ.



Хэнд хамаатуулан Хуулийг хэрэглэх вэ ?

1. **Хэрвээ Та**- үндэсний эсвэл олон улсын түвшний тамирчин бол Хуулийг Танд хамаатуулан хэрэглэнэ.

“Олон улсын түвшний” тамирчдыг Олон улсын Холбоо тодорхойлно. “Үндэсний түвшний” тамирчдыг Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллага тодорхойлно.

2. **Хэрвээ Та** - тус газрын түвшний тэмцээнд оролцож байгаа ба “Үндэсний түвшний” тамирчны тодорхойлтонд орохгүй тохиолдолд Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллага Танд хамаатуулан Хуулийг хэрэглэх эсэхийг өөрөө биеэ даан шийдэх ба хэрвээ хэрэглэх тохиолдолд ямар байдлаар хэрэглэх тухай шийдвэрлэнэ. Хэрвээ Та ийм түвшинд тэмцээнд оролцвол Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллага нь Танд сорил хийх ба хэрвээ Таны дээж эерэг гарах эсвэл сэргээш-хяналтын үйл ажиллагаанд оролцох оролдлого хийсэн байх, эсвэл сэргээшийн эсрэг дүрмийн өөр бусад зөрчил үйлдсэн тохиолдолд Хуулийн шаардлагын дагуу Танд хамаатуулан хориг арга хэмжээ хэрэглэнэ.

3. **Хэрвээ Та** - тэмцээнд оролцохгүй боловч эрүүл мэндийн болон фитнес арга хэмжээнд оролцох бол Танд хамаатуулан Хуулийг яаж хэрэглэх тухай Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллага өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ.

Тамирчид тодорхой үүргүүдтэй:

☒ Бүх “хэрэглэгддэг сэргээшийн эсрэг зарчимууд болон дүрмүүдийг” мэдэж, мөрдөж байх үүрэгтэй,

☒ Та “дотуур хэрэглэж байгаа” зүйлдээ хариуцлага хүлээнэ, тэр дундаа хоол ундандаа хэрэглэж байгаа зүйлдээ болон Таны биемахбодод орж байгаа зүйлдээ хариуцлага хүлээнэ. Дүрмийн энэ үндэслэл нь дараахь зүйлийг агуулна: Таны биемахбодод ямарваа нэгэн зүйл орсон л бол Та үүнд хариуцлага хүлээнэ. Хууль эрх зүйн талаас үүнийг “хатуу чанга хариуцлага” гэж нэрлэдэг.

☒ Дээж авахад Та нээлттэй байх,

☒ Та эрүүл мэндийн ажилтанд Танд хориотой бодис эсвэл хориотой аргыг өгөхгүй байх үүрэгтэй гэдгийг мэдээлж байх. Таны авч байгаа ямарваа нэгэн дурын эрүүл мэндийн эмчилгээ нь Хуулийг зөрчихгүй байгааг шалгаж байх үүрэгтэй.

☒ Сэргээшийн эсрэг дүрмийн зөрчилийг судалдаг сэргээшийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах.

☒ Илүү тодорхой мэдээллийг авахын тулд 21.2-р хэсгийг харна уу.

Тамирчны дасгалжуулагчид, зааварлагчид, менежерүүд, агентлагууд болон бусад ажилчид нь ихэнхдээ тамирчдад үлгэр дууриалал болдог. Тэдгээр нь тодорхой эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- ☑ Бэлтгэл хийж байгаа тамирчдад эсвэл тэд нарт хэрэглэгдэх сэргээшийн эсрэг зарчим болон дүрмүүдийг мэдэж, мөрдөж байх ёстой.
- ☑ Тамирчдын сорилын хөтөлбөрт хамтран ажиллах ёстой.
- ☑ Спортын философийг цэвэр ариун байлгах зорилгоор тамирчдад өөрийн нөлөөгөө үзүүлэх.
- ☑ Сэргээшийн эсрэг дүрмийн зөрчлийг судалдаг сэргээшийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах.
- ☑ Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хориотой бодис эсвэл хориотой аргыг хэрэглэхгүй байх.
- ☑ Илүү тодорхой мэдээллийг авахыг хүсвэл 21.2-р хэсгийг харна уу.

5-р ХЭСЭГ. СЭРГЭЭШ ГЭЖ ЮУ ВЭ ?

Та тамирчны хувьд сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн тохиолдолд юу болохыг мэдэж байх ёстой гэдгийг Хуульд заасан байдаг.

Ийм зөрчил нь зөвхөн эерэг дээж биш юм.

Ийм зөрчил нь Хуульд “Шинжилгээний таатай бус үр дүн” гэж нэрлэдэг зөвхөн эерэг дээж биш юм.

Жишээлбэл: сэргээшийн эсрэг дүрмийн зөрчил гэдэг нь хориотой бодис хэрэглэх эсвэл хориотой арга хэрэглэх явдал юм.

Мөн сэргээшийн эсрэг дүрмийн өөр зөрчилүүд байдаг. Үүнийг Хууль дараахь байдлаар тайлбарладаг:

☑ Сэргээш-хяналтын дурын бүрэлдхүүнд хуурамчаар бүрдүүлэлт хийх эсвэл хуурамчаар бүрдүүлэх оролдлого хийх, жишээлбэл: сэргээш-хяналтын үйл ажиллагаанд санаатайгаар оролцох, боломжит гэрчийг айлган сүрдүүлэх эсвэл хөндлөнгийн бодисыг нэмэх замаар дээжийг солих. 2.5-р хэсгийг харна уу.

☑ Хориотой бодис эсвэл хориотой аргатай болох. Эрүүл мэндийн шалтгаанаар тодорхой хязгаартай тохиолдолоос бусад тохиолдолд бусдад дамжуулах эсвэл төрөл садандаа өгөх зорилгоор биедээ хориотой бодис авч явах эсвэл худалдан авч болохгүй, жишээлбэл: чихрийн шижин өвчтэй хүүхдэд инсулин авах, 2.6-р хэсгийг харна уу.

☑ Хориотой бодис эсвэл хориотой аргыг түгээн дэлгэрүүлэх эсвэл түгээн дэлгэрүүлэх оролдлого хийх. 2.7-р хэсгийг харна уу.

☑ Ямар нэгэн тамирчинд хориотой бодис эсвэл хориотой аргыг хэлж өгөх. 2.8-р хэсгийг харна уу.

☑ Хамтрах. Энэ нь үйлдэл өргөн хүрээг хамрана: тусламж, дэмжих, өдөөх, хуйвалдах, нуун дарагдуулах эсвэл аливаа санаатай оролцоо мөн сэргээшийн эсрэг дүрмийг зөрчих эсвэл “бусад этгээд” зөрчих оролдлого. 2.9-р хэсгийг харна уу.

☑ Хориотой хамтын ажиллагаа. 2.10-р хэсгийг харна уу.

☑ Байгаа газрыг мэдээллэх дүрмийг зөрчих. 2.4-р хэсгийг харна уу.

☑ Дээжийг өгөх үйл ажиллагаанд ирэхгүй байх, татгалзах эсвэл зайлсхийх. 2.3-р хэсгийг харна уу.

Та сэргээшийн эсрэг дүрмийн зөрчлийг дурын найдвартай аргаар баталж болох тухай мэдэж байх ёстой. Үүнд: лабораторийн судалгааны үр дүн болон бусад баталгаанууд болох “шинжилгээний бус” баталгаанууд багтана. Баталгаанууд нь хязгаарлагдахгүйгээр “тамирчны биологийн паспорт” (тамирчны биологийн үзүүлэлтүүдийн урт хугацааны судалгаа) гэрчүүдийн мэдээлэл болон бусад янз бүрийн баримтжуулсан баталгаануудыг багтаана.



Сэргээшийн эсрэг дүрмийг зөрчих санаа нь чухал уу?

Дүрмэнд бичсэнээр Таны биемахбодод агуулагдаж байгаа бүх зүйлд Та хариуцлага хүлээнэ. Хориотой бодисыг хэрэглэж сэргээшийн эсрэг дүрэм зөрчсөнийг тогтоохын тулд санаа бодол, буруутай байдал, хайхрамжгүй байдал эсвэл санаатай хэрэглээг тодотгох шаардлагагүй.

Жишээлбэл, Таны эргэн тойронд байгаа хэн нэгэн эсвэл сургалт-бэлтгэлийн цугларалтанд Танд хориотой бодис өгсөн эсвэл бүтээгдэхүүний хаяг дээр хориотой бодисыг заагаагүй, эсвэл хориотой бодис эсвэл арга нь таны спортын үр дүнд сайнаар нөлөөлөөгүй ч гэсэн энэ нь сэргээшийн эсрэг дүрмийг зөрчлийг цагаатгах шалтгаан болохгүй.

Хэрвээ Та хориотой бодис эсвэл аргыг хэрэглэх эсвэл хэрэглэх оролдлого хийсэн тохиолдолд энэ нь сэргээш болно. Хэрэглэсэн эсвэл хэрэглэх оролдлого “Амжилт” эсвэл “Бүтэлгүйтэл” нь хамаарахгүйгээр үүнийг сэргээш гэж тооцно.

Тодорхой мэдээлэл авахын тулд 2.1 ба 2.2-р хэсгийг харна уу.

Ямарваа нэгэн зүйлийг агуулж байгаа болов уу гэсэн бага ч гэсэн эргэлзээ байгаа бол Та нэмэлтүүдийг хэрэглэхгүй байх ёстой.

Биологийн идэвхит нэмэлтийг хэрэглэх эрсдэл

Олонхи орнуудад биологийн идэвхит нэмэлтүүдийн зохицуулалт сул байдаг. Хориотой бодис агуулсан нэмэлтүүд нь хүнсний бүтээгдэхүүний дэлгүүрт зарах эсвэл шошго дээр нь ямар нэгэн заалт байхгүй интернетээр зарах тохиолдол ховор биш билээ. Сүүлийн жилүүдэд ихэнх эерэг дээж нь буруу батлагдсан эсвэл бохирдсон нэмэлтүүдээр тайлбарлагддаг.

Жишээлбэл: сүүлийн жилүүдэд янз бүрийн орны тамирчид хориотой сэргээш болох метилгексанамин (МНА) агуулсан эерэг дээжийг өгсөн олон тохиолдол бий, үүнд Олимпийн тэмцээнүүд орно. Энэ сэргээш нь «диметилпентиламин» эсвэл DMAA нэртэй, мөн тарлан цэцгийн үндсийн ханд эсвэл тарлан цэцгийн масло гэсэн нэртэйгээр алдаршсан. Тухайн нэрүүд нь шошго дээр нь бичигдсэн эсвэл бичигдээгүй байж болно. “Метилгексанамин” нь хэдийгээр хориотой Жагсаалтанд орсон ч бүтээгдэхүүний шошго дээр заах нь ховор байдаг.

Булчингийн хэмжээг томруулдаг, сэргээхэд тусалдаг, энерги өгдөг эсвэл жинг хасахад тусалдаг нэмэлтүүдэд анхааралтай хандах хэрэгтэй. Буруу тэмдэглэгдсэн нэмэлтүүдийг хэрэглэсний үр дүнд бий болсон эерэг дээжийн үр дагаварт Та хатуу хариуцлага хүлээх болно. Сайн зөвлөгөө: ***Ямарваа нэгэн зүйлийг агуулж байгаа болов уу гэсэн бага ч гэсэн эргэлзээ байгаа бол Та нэмэлтүүдийг хэрэглэхгүй байх ёстой.***

“Байрлах газар” дүрэм

Байрлаж байгаа газрын тухай мэдээлэл өгөх шаардлагын үндсэн зорилго нь тэмцээний гаднах сорилт явуулах явдал юм.

Гэнэтийн сорил нь сэргээшийн эсрэг үр ашигтай хөтөлбөрийн үндэс юм.

Байршилын тухай мэдээлэл олгох нь сэргээшийн эсрэг байгууллага таны байгаа газрыг толорхойлох боломжтой болох ба гэнэтийн шалгалтаар сэргээш хэрэглэсэн тамирчдын тоог ихэсгэхэд тустай. Гэнэтийн сорил нь ***сэргээшийн эсрэг үр ашигтай хөтөлбөрийн үндэс юм.***

“Сорилд бүртгэгдсэн ПУЛ”-д багтдаг харьцангуй хэдхэн тамирчид өөрийн байршилын тухай тодорхой мэдээллийг мэдээлж байх үүрэгтэй.

Хэрвээ таныг “Сорилд бүртгэгдсэн ПУЛ”-д орж байгаа тухай мэдээлсэн бол Та өөрийн байршилынхаа тухай улирал болгон мэдээлж байх үүрэгтэй.

Та сорилд ороход бэлэн байх үүрэгтэй тул өөрийнхөө төлөвлөсөн болон өдөр тутмын цагийн байдлыг мэдэж байх ёстой. Сорилтод зориулж өөрийн мэдээллээ тогтмол шинэчлэж байх ёстой.

☒ **Хэрвээ Та цаг хугацаанд нь улирал болгоны мэдээллээ өгөөгүй бол Та мэдээллээ өгөөгүй зөрчил үйлдсэн.**

☒ **Хэрвээ Та өдөр болгоны цагийн байдлыг заасан газар байгаагүй бол Та сорилтыг өнгөрүүлсэн зөрчил үйлдсэн.**

Дурын боломжит мэдээллийг олгоогүй эсвэл сорилтыг өнгөрүүлсэн зөрчилийг Та зохих ёсны Сэргээшийн эсрэг байгууллагын өмнө давж маргалдах эрхтэй. Гурван удаа өнгөрүүлсэн сорил эсвэл байршилын тухай бүртгэгдсэн мэдээлэл олгоогүй байдлыг 12 сарын дотор Та давж заалдаагүй бол сэргээшийн эсрэг дүрмийг зөрчисөнд тооцно. Хэрвээ Та спортын багийн тэмцээнд орж байгаа ба “Сорилд бүртгэгдсэн ПУЛ”-д орж байгаа тохиолдолд спортын ганцаарчилсан төрөлд орж буй тамирчидтай адил байршилын тухай мэдээлэл өгөх шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Спортын багийн эсвэл ганцаарчилсан төрлийн тэмцээнд орж байгаа тамирчин нь өөрийн байршилын тухай мэдээллээ дасгалжуулагч, менежер эсвэл дурын гуравдагч талд даалгаж болох боловч тамирчин болгон эцэст нь байршилын тухай тодорхой болон бүрэн мэдээллэд хариуцлага хүлээнэ.

Багийн байрлаж байгаа мэдээллийг багийн үйл ажиллагаанд зориулан сэргээшийн эсрэг байгууллагад олгоно. Сорилт болон Судалгааны Олон улсын Стандарт, 4.8.2-р хэсгийг харна уу.

“Сорилд бүртгэгдсэн ПУЛ”-д ороогүй тодорхой тамирчдаас сэргээшийн эсрэг байгууллага нь байршилын тухай тодорхой мэдээллийг олгохыг хүсэж болно. Хэрвээ Та эдгээр тамирчдын нэг нь бол байршилын тухай шаардлагын дагуу мэдээлэл олгоогүй байдал нь сэргээшийн эсрэг зөрчил гэж тооцогдохгүй боловч таны сэргээшийн эсрэг байгууллагын тогтоосон бусад үр дагаврыг дагуулж болно.



“Хориотой хамтын ажиллагаа” гэж юу вэ ?

Спортын үр дүнг сайжруулсан бэлдмэлийг бусдад олгож зөрчил үйлдэн эрүүгийн хуулийн дагуу буруутгагдаж хасагдсан дасгалжуулагчид эсвэл эрүүнийн хуулийн дагуу зөрчил үйлдсэн бусад иргэнтэй үргэлжлүүлэн ажиллаж байсан тамирчид байсан тухай нийтэд өргөн тархсан хэд хэдэн жишээ байдаг.

2015 оны эхээр хүчин төгөлдөр болсон Хуулийн шинэчлэл нь ийм хамтын ажиллагаа хориотой гэдгийг тусгайлан сануулсан цагаас эхлүүлэн хэрвээ Та “ийм ажилтантай ”хамтран ажиллаж байгаа бол сэргээшийн эсрэг дүрмийг зөрчиж байгаа гэж тооцно.

ДЭЛГЭРЭНГҮЙ БАЙДАЛ:

Сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөнөөс болж хасагдсан эсвэл эрүүгийн хэргээр буруутай гэж тооцогдсон эсвэл сэргээшт хамааралтай сахилгын судалгааны явцад хасагдсан дасгалжуулагч, зааварлагч, эмч эсвэл тамирчдын бусад ажилтангуудтай ажиллаж болохгүй.

Хориотой хамтын ажиллагааны жишээ нь: бэлтгэл, стратеги, техник, хоол тэжээл эсвэл эрүүл мэндийн зөвлөлгөө авах, эсвэл эмчилгээ эсвэл эмчилгээний жор авах, агентлаг эсвэл төлөөлөгч гэж ажилтанг ажиллуулах зөвшөөрөл олгох гэх мэт үйлдлүүд орно. Хориотой хамтын ажиллагаа нь нөхөн олговрын ямарваа нэгэн хэлбэрийг хэлэх албагүй билээ.

Тухайн байдал нь мэргэжлийн эсвэл спорттой холбоотой харилцаанд хамаардаггүй нөхцөл байдалд хэрэглэгдэхгүй. Жишээлбэл: эцэг эх болон хүүхдийн хоорондох, нөхөр эхнэрийн хоорондох харьцаа.

Илүү тодорхой мэдээллийг авахын тулд 2.10-р хэсгээс харна уу.

Ямар бодис болон аргууд нь хориотойд тооцогдох вэ ?

ОУСЭА-ийн хориотой арга болон хориотой бодисын жагсаалтууд байдаг. Жилд нэг удаа ОУСЭА нь тухайн Хориотой жагсаалтыг шинэчлэдэг. Шинэчилсэн Жагсаалт нь жил бүрийн 01-р сарын 01-нээс хүчин төгөлдөр болдог ба ОУСЭА –н сайтад хэдэн сарын өмнө тавигддаг.

Хориотой жагсаалтанд ямар бодис болон аргууд ордогийг Та мэдэж байх ёстой:

Жагсаалт нь дараахь бодисуудад хуваагддаг:

1. Тогтмол хориотой,

2. Зөвхөн тэмцээний явцад хориотой (тус тусдаа спортын төрөл болгон дээр тодорхойлогдоно, дүрмийн дагуу тэмцээн эхлэхээс өмнө 24 цагийн өмнө)

Тогтмол хориотой бодисонд (хязгаарлагдахгүй): гормонууд, анаболикууд, ЭПО, бета-2 агонистууд, шээс хөөх эм бодисууд, нуугдмал агентууд орно.

Зөвхөн тэмцээний явцад хориотой бодисуудад: өдөөгч, марихуан, хар тамхи, глюкокортикостероидууд орно.

Ямар ч цаг хугацаанд хориотой: дараахь аргууд орно: цус сэлбэх эсвэл нарийн төвөгтэй арга, тодорхой байдалд судсанд хийх.

Тогтмол хориотой болон тэмцээний явцад хориотой бодисууд хоорондоо ямар ялгаатай вэ?

Тогтмол хориотой бодисууд- бэлтгэл болон тэмцээнийг багтааж жилийн турш хориотой байдаг бодисууд орно. Жишээлбэл: спортын үр дүнг сайжруулах явцад урт удаан нөлөө үзүүлж болох бэлтгэлийн үед хэрэглэдэг анаболический стероид эсвэл сэргээш хэрэглэснийг нуухад хэрэглэдэг нуугдмал агентууд орно.

Үүнээс ялгаатай нь тэмцээний үед, тэмцээнээс гадаархи үед хориотой бодисуудыг хэрэглэж тухайн бодисын үлдэгдэл нь тэмцээний сорилын үед таны биемахбодод агуулагдаагүй бол сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөнд тооцохгүй.

Ойлгомжтой болохын тулд: ихэнх бодисууд нь Таны биемахбодод удаан хугацаанд үлддэг. Хэрвээ тэмцээнээс гадуурхи үед Таны тэмцээний сэргээш дээжинд хэрэглэсэн бодис олдвол (түүнийг хэрэглэх үед хориотой байгаагүй) Таныг сэргээшийн эсрэг дүрмийг зөрчисөнд тооцно.

Хориотой бодис нь жирийн эмэнд агуулагдаж болох уу?

Тийм. Дурын жирийн эм, ханиаданд хэрэглэгдэг бэлдмэлүүд, өвчин намдаах эмүүдэд хориотой бодис агуулагдсан байж болно.

Тодорхой мэдээлэл авахын тулд Танай Олон улсын Холбоо эсвэл Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллагаас олгох бусад эх үүсвэрийг харна уу.



ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХИЙГ ЗӨВШӨӨРӨХ

Сэргээштэй тэмцэх гол зарчим нь Таны эрүүл мэндийг хамгаалах явдал юм.

Эрүүл мэндтэй холбоотой шалтгаанаар Танд хориотой бодис эсвэл хориотой арга хэрэглэх шаардлага гарна. Үүнийг Хуулийн дагуу хийх ёстой. Энд түлхүүр гол зарчим нь эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл авах ёстой.

Тухайн зөвшөөрлийг авахын тулд зарим нэгэн шалгуурыг давах шаардлагатай: хориотой бодис эсвэл хориотой арга хэрэглэхээс бусад тохиолдолд хориотой бодисыг хэрэглэх нь Таны эрүүл мэндэд шаардлагатай ба эрүүл болсоны дараа таны спортын үр дүнд нөлөөлөхгүй, эмчилгээнд ямар ч өөр сонголт байхгүй

Олон улсын болон үндэсний түвшний тамирчид дүрмийн бас нэг өөр асуудлыг ойлгох хэрэгтэй: яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд эсвэл онцгой байдалд эмчилгээнд хэрэглэх зөвшөөрлийн хүсэлтийг хамгийн сүүлийн хугацаанд биш өмнө нь өгөх ёстой. Эмчилгээнд хэрэглэх Олон улсын Стандартын 4.3-р хэсгийг харна уу.

Үндэсний түвшний тамирчдад олгох зөвшөөрлийг Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллага олгоно.

Олон улсын түвшний тамирчдад зориулсан эмчилгээний хэрэглээний хүсэлтийг Олон улсын Холбоо олгоно. Олимпийн тэмцээн болон бусад томоохон олон улсын тэмцээнийг зохион байгуулагчид тусгай зөвшөөрлийг олгож болно. 4.4-р хэсгийг харна уу.

Та өөрийн Олон улсын Холбоо эсвэл Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллагаас шинэ хүсэлтийг хэзээ өгч болох эсвэл өмнө нь өгсөн захиалга хүлээн зөвшөөрөгдсөн эсэх тухай тодруулах шаардлагатай. Танай Үндэсний Сэргээшийн эсрэг Байгууллага нь тухайн процессын явцад тусламж үзүүлэх үүрэгтэй.

Үндэсний түвшинд өгсөн зөвшөөрөл нь автоматаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөн гэж бодож болохгүй. Хэрвээ Танд бага ч гэсэн эргэлзээ байгаа бол өөрийн Олон улсын Холбоо эсвэл томоохон спортын арга хэмжээг зохион байгуулагч нартай холбогдох ёстой.

Тухайн процессыг тайлбарлаж байгаа хэсэг нь Эмчилгээнд хэрэглэх Олон улсын Стандартын Хавсралтанд орсон байгаа.

СОРИЛТ, ДЭЭЖИЙН ШИНЖИЛГЭЭ БОЛОН ЦУГЛУУЛГА

Сэргээш-хяналтын бүрэн эрхт төлөөлөгч Таныг дээжээ өгөхийг хүсвэл Та үүнийг хийх үүрэгтэй. Шүүн таслах эрхтэй ямар ч сэргээшийн эсрэг байгууллага нь сэргээшийн эсрэг зорилгоор дээжийг шинжилгээнд өгөхийн тулд ямар ч хугацаанд, ямар ч газарт тамирчнаас шээсний ба /эсвэл цусны дээжийг цуглуулах эрхтэй.

Хэн шүүн таслах эрхтэй вэ ?

Үндэсний сэргээшийн эсрэг байгууллага нь дараахь тамирчдад шүүн таслах эрхтэй:

1. лиценз эзэмшигч, иргэд, оршин суугчид эсвэл тухайн орны спортын байгууллагын гишүүн эсвэл,
2. энэ сэргээшийн эсрэг байгууллагын улс оронд байгаа хэн нэгэнд эсвэл,
3. Олон улсын Холбооны дүрэм нь тэдгээрт бүрэн эрхийг олгож байгаа тохиолдолд.

Дүрмийн нөлөөнд багтдаг тамирчдад Олон улсын Холбоо шүүн таслах эрхтэй:

1. Тодорхой олон улсын үйл явдалд оролцдог тамирчид,
2. Тухайн олон улсын холбооны (түүний шууд болон шууд бус гишүүд) лиценз эзэмшигчид эсвэл түүний гишүүд болох тамирчид .

Томоохон спортын арга хэмжээг зохион байгуулагчид нь спортын үйл явдалд оролцох тамирчдыг шүүн таслах эрхтэй.

ОУСЭА нь ихэвчлэн сорилтыг санаачладаггүй, гэвч тамирчдыг сорих шүүн таслах эрхтэй. ОУСЭА сорилтыг санаачилсан тохиолдолд ОУСЭА нь сорилт явуулах бүрэн эрхээ бусад сэргээшийн эсрэг байгууллагад шилжүүлдэг.

Дээж өгөх үйл ажиллагаанд тогтоосон дүрэм байдаг. Тухайн дүрмийн тухай илүү ихийг мэдэхийн тулд ба тухайн үйл ажиллагааны явцад эдлэх өөрийн эрхээ мэдэхийн тулд Хавсралт 1 харна уу.

Тамирчны дээжинд хориотой бодис ажиглагдсантай холбоотой зөрчилийг тогтоох зорилгоор зөвхөн магадлан итгэмжилэгдсэн эсвэл ОУСЭА хүлээн зөвшөөрсөн лабораторт дээжийн шинжилгээг явуулна. Хэрвээ Таны А дээжийн шинжилгээний таатай бус үр дүн гарсан ба В дээжийн шинжилгээтэй холбоотой өөрийн эрхээ мэдэхийн тулд Хавсралт 2 харна уу.

Дээж хэрхэн удаан хадгалах вэ ?

Дээжийг хөлдөөж болно, 10 жилийн турш хадгалж, дахин шалгагдана. Технологи хурдан хөгжиж байгаа билээ. Өнөөдөр илрээгүй зарим нэгэн хориотой бодис болон хориотой арга ирээдүйд илэрч болно.

Хадгалагдаж байгаа дээжийг дараагийн шинжилгээнд оруулах боломжтой тул Танд зориулагдсан хүчтэй хүчин зүйл байх ёстой эсвэл Та сэргээшийг Таны мэддэг хэн нэгэнд ямар нэгэн шалтгаанаар хэрэглэх.

Дээжийг сэргээшийн эсрэг зорилгоор дахин хэрэглэхгүй тохиолдолд тэдгээрийн нэрийг заахгүйгээр чанарын хяналтын зорилгоор хэрэглэх, устгах эсвэл сэргээш-хяналтын протоколд Таны бичгээр өгсөн урьдчилсан зөвшөөрлийн дагуу шинжлэх ухааны судалгаанд зориулан ашиглах.

Спортоос гарсаны дараа спортонд эргэн орох

Хэрвээ Та Олон улсын Холбооны сорилд бүртгэгдсэн пул эсвэл Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллагад байхдаа спортоос гарах шийдвэр гаргасан бол тэмцээнд оролцох өөрийнхөө хүсэлтийг 6 сарын өмнө бичгээр мэдэгдэнэ. Энэ 6 сарын турш Та сэргээшийн эсрэг дүрмийг мөрдөхөө зөвшөөрч тэмцээнд оролцохоос өмнө Таныг сорилд оролцуулхаар бэлэн байлгана.

Хэрвээ тухайн дүрмийн хатуу чанга хэрэглээ нь “илтэд шударга бус” байвал ОУСЭА нь хасалт хийж болно. 5.7-р хэсгийг харна уу.

АДАМС (Сэргээшийн эсрэг Захиргааны болон Удирдлагын Систем) гэж юу вэ

СЭЗБУС (Сэргээшийн эсрэг Захиргааны болон Удирдлагын Систем) нь өгөгдлийн сангийн удирдлагын аюулгүй онлайн систем юм. СЭЗБУС нь шинжилгээний үр дүнгийн үзүүлэлт, эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл болон сэргээшийн эсрэг дүрмийн зөрчилийн тухай мэдээллийг агуулдаг. СЭЗБУС нь зохих ёсны байгууллагууд хооронд мэдээллийн солилцоог хөнгөвчилдөг ба үр ашигтай, үр бүтээлтэй, тунгалаг байлгахад чиглэгддэг.

Ихэнх Олон улсын Холбоо болон Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллагууд нь СЭЗБУС системийг тамирчны байгаа газрын үндсэн бааз, сорилын үр дүн болон эмчилгээнд хэрэглэхэд суурь бааз гэж хэрэглэдэг.

СЭЗБУС системд Таны мэдээлэлд хандалт хийж болно. Олон улсын Холбоо болон Үндэсний Сэргээшийн эсрэг байгууллага Таныг СЭЗБУС-д хандахад хариуцлага хүлээнэ. Сэргээшийн эсрэг байгууллагын хязгаарлагдсан цөөн тооны ажилчид Таны мэдээлэл рүү хандах эрхтэй. СЭЗБУС нь хандалтын олон шатлалт систем, нууцлал болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалдаг.



СЭРГЭЭШИЙН ЭСРЭГ ДҮРМИЙГ ЗӨРЧИХӨД ГАРАХ ҮР ДАГАВАР

Сэргээшийн эсрэг дүрмийг зөрчихөд гарах үр дагаврууд: үр дүнг цуцлах, торгууль тавих, Таны зөрчилийг зайлшгүй нийтлэх мөн санхүүгийн хориг арга хэмжээ тавих боломжтой.

ҮР ДҮНГ ЦУЦЛАХ

Спортын ганцаарчилсан төрлийн тэмцээнтэй холбоотой сэргээшийн эсрэг дүрмийг зөрчихөд тухайн тэмцээний үр дүнг автоматаар цуцалдаг. 9-р хэсгийг харна уу.

Цуцлалт гэж юу вэ ?

Энэ нь үр дүн, одон шагнал, дүн болон шагналын мөнгө алдана гэсэн үг билээ. Энэ үйл явдалын хугацаанд өөр тэмцээнд үзүүлсэн Таны үр дүн мөн цуцлагдаж болно. жишээлбэл: Олимпын үер. 10.1-р хэсгийг харна уу.

“Шударга ёс өөр зүйл шаардаагүй бол” үр дүнг хамгийн сүүлийн огноогоор цуцлана- эрхийг нь хасах хугацаа эхлэхээс сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн огноогоос түр зуур зогсоосон огноо хүртэл (жишээлбэл, дээж авсан огноогоор). 10.8-р хэсгийг харна уу.

ЭРХ ХАСУУЛАХ

Эрх хасуулах гэдэг нь Та ямар ч тэмцээнд эсвэл Олон улсын Холбоо, түүний үндэсний холбооны гишүүн болон клубууд, тэдгээрийн гишүүдийн спортын үйл ажиллагаанд оролцож чадахгүй гэдгийг илэрхийлнэ.

Энэ нь өөрийн клуб эсвэл багтай хамтарч бэлтгэл хийх, баг болон клубтэй холбоотой спортын тоног төхөөрөмжийг ашиглах зэргүүд багтана.

Мөн Та Хуулийг баталсан эсвэл зохион байгуулсан тал (Олон улсын Олимпын Хороо, Олон улсын Параолимпын Хороо Үндэсний Олимпын Хороо) эсвэл тэдгээрийн харьяа байгууллагын тэмцээнд оролцож чадахгүй юм.

Засгийн газрын байгууллага санхүүжүүлсэн үндэсний эсвэл өндөр түвшний спортын арга хэмжээ, олон улсын эсвэл үндэсний зохион байгуулагчдын, эсвэл мэргэжлийн лигийн зохион байгуулсан үндэсний эсвэл олон улсын тэмцээнд оролцож чадахгүй гэсэн үг билээ. 10.12.1-р хэсгийг харна уу.

Хасагдах хугацаа нь хир удаан үргэлжлэх вэ ?

Санаатайгаар үйлдэл хийсэн хууран мэхлэгчдийг, ялангуяа тамирчдын дунд, 4 жилийн хугацаатайгаар эрхийг нь хасах тухай дэлхий дахин зөвшилцөлд хүрсэн.

Хугацаа нь байнга 4 жил байх уу ?

Үгүй.

Сэргээшийн эсрэг дүрмийг зөрчихөд эрхийг хасахгүй байж болох уу ?

Болно, гэхдээ хэрвээ тамирчин өөрийн буруу эсвэл хайхрамжгүй байдлаа баталж чадвал.

Мөн онцгой бодисын хувьд мөн зарим нэгэн онцгой байдалд хэрвээ тамирчны буруу маш бага байвал анхааруулга өгч болно. Мөн ийм зарчим нь бохирдсон бүтээгдэхүүнд хамааралтай- интернетээр олж болох мэдээлэл эсвэл шошго дээр нь бичигдээгүй хориотой бодис агуулсан бүтээгдэхүүн- ихэвчлэн биологийн идэвхит нэмэлтүүдэд мөн хамааралтай.

Эрх хасах үе нь ямар хүчин зүйлсээс хамаарах вэ ?

Хэрэглэсэн хориотой бодис эсвэл хориотой аргын зөрчилийн төрөл, тамирчны зан төлөв болон тамирчны буруутай үйлдлийн зэрэглэл.

ЭДГЭЭР ДҮРМҮҮД НЬ НЭГ НЭГТЭЙГЭЭ ХЭРХЭН НИЙЦДЭГ ВЭ?

Хориотой бодис хэрэглэсэн эсвэл хориотой бодис байгаагаар холбоотой зөрчилд үндсэн дүрмүүд нь дараахь байдалтай хэрэгжнэ:

Хэрвээ Та бодисоос хамаарахгүйгээр хууран мэхлэх гэж байсан тохиолдолд эрх хасах хугацаа нь 4 жил байна.

Өөр тохиолдолд- 2 жил- хэрвээ Та буруугүй гэдгээ эсвэл хайхрамжгүй байдлаа баталж чадвал эрх хасахыг хамгийн ихээр 1 жил хүртэл бууруулж болно (ингээд, эрх хасалтын хамгийн бага хугацаа нь нэг жил байна)

Хэрвээ зөрчил нь онцгой бодис эсвэл бохирдсон бүтээгдэхүүнтэй холбоотой ба Та буруугүй гэдгээ баталж чадвал эрх хасалтыг 2 жилээс анхааруулга болтол өөр өөр байна (буруутай үйлдлийн зэрэглэлээс хамаарна). Сэргээшийн эсрэг дүрмийн бусад зөрчилийн эрх хасалтыг 10.3-р хэсгээс харна уу.

Хамтын ажиллагаа болон “бодитой дэмжлэг”

Өөрийн алдаагаа хүлээн зөвшөөрсөн болон сэргээшийн эсрэг дүрмийн бусад зөрчилийг илрүүлэх хүсэлтэй тамирчдын болон бусад этгээдийн хамтын ажиллагаа цэвэр спортод чухал билээ.

Үүнийг Хууль онцгой байдал гэж тооцдог.

Хэрвээ сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн тухай мэдэгдэл авахаас өмнө тамирчин нь сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн тухайгаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн бол эрх хасах хугацааг багасгаж болно (гэхдээ заагдсан хугацааны талаас илүүгүй хугацаагаар) ба үүний хамт энэ хүлээн зөвшөөрсөн байдал нь зөрчилийн цорын ганц үнэн зөв нотолгоо болно- өөрөөр хэлбэл тухайн тамирчин нь өөрөө хүлээн зөвшөөрсөн бол.

Эрх хасах хугацаа нь дараахь тохиолдолд их хэмжээгээр буурч болно- тамирчин нь сэргээшийн эсрэг байгууллага, цагдаагийн байгууллага, хууль сахиулах байгууллага эсвэл мэргэжлийн сахилгын байгууллагад “бодитой дэмжлэг” үзүүлж үүний үр дүнд сэргээшийн эсрэг байгууллага өөр этгээдийн үйлдсэн сэргээшийн эсрэг дүрмийн зөрчилийн шинэ хэргийг нээсэн бол (эсвэл үүнийг хийх боломжийг нээсэн бол).

“Бодитой дэмжлэг” гэж юу вэ? Өөр этгээд, өөрийгөө оруулан, сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн тухай бичгээр бүрэн бүтэн илрүүлэхийг хэлнэ. Мөн бүрэн хэмжээгээр засаг захиргаатай хамтран ажиллах, тэр дундаа хэрвээ шаардлагатай бол шүүх хуралд мэдүүлэг өгөхийг хэлнэ.

Тодорхой мэдээллийг авахын тулд 10.6.1 болон 10.6.2-р хэсгийг харна уу.

ЭРХ ХАСАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ НЭГЭН ҮЙЛДЛИЙН ДЭС ДАРААЛАЛ

☒ *Хэрвээ Та сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөнд буруутгагдвал Таны эрхийг түр зуур хасах эсвэл Та өөрөө сайн дураараа түр зуур оролоцхгүй байж болно- өөрөөр хэлбэл давж заалдах эрхээсээ татгалзах*

☒ *Эрх хасах хугацаа эхлэх:*

1. *Түр зуурын хугацаанд эрх хасах огноогоос эсвэл тавигдсан хориг арга хэмжээ тавигдсан огноогоос,*

2. Маргаантай тохиолдолд, хурал дээр шийдвэр гаргасан огноогоос

☒ *Хэрвээ Та хасах эрх эдэлж байгаа бол зохих ёсны сэргээшийн эсрэг боловсролын программд оролцож болно.*

☒ *Мөн Та багтайгаа хамт бэлтгэлдээ буцаж орж болох эсвэл клубын байрыг хэрэглэж болно, :*

- 1. Таны эрх хасуулснаас сүүлийн 2 сарын, эсвэл*
- 2. Эрх хасуулсан хугацаанаас сүүлийн дөрөвний нэг. 10.12.2-р хэсгийг харна уу.*

☒ *Тайлбар: зарим нэгэн тохиолдолд түр хугацаагаар хойшлуулсан байдал нь зайлшгүй байх ёстой, 7.9.1-р хэсгийг харна уу.*

САНХҮҮГИЙН ҮР ДАГАВРУУД

Сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн тохиолдолд торгууль тавихыг Хууль заадаагүй. Гэвч энэ нь сэргээшийн эсрэг байгууллага нь дүрмийн дагуу торгуулийг тогтооход саад болохгүй гэсэн үг.

Санхүүгийн хориг арга хэмжээ нь хэзээ ч эрх хасах хугацааг багасгахгүй эсвэл орлуулж чадахгүй. Санхүүгийн боломжтой тамирчид өөрийнхөө эрх хасуулах хугацаагаа төлж чадахгүй. Илүү тодорхой мэдээллийг 14.3.2-р хэсгийг харна уу.

ОЛОН НИЙТЭД ЗАЙЛШГҮЙ ТУНХАГЛАХ

Хэрвээ Таныг сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөнд тооцсон бол тухайн байдлыг олон нийтэд мэдэгдэнэ. Тухайн санаа нь сэргээшид зориулсан хүчин зүйлийн гол саад болох ёстой.

Сэргээшийн эсрэг байгууллага, насанд хүрээгүй тамирчид оролцсоноос бусад тохиолдолд, сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн шийдвэрээс гарсан огноогоос 20 хоногоос хэтрэхгүйгээр тамирчны нэрийг олон нийтэд тунхаглана.

Хэрвээ эцсийн шийдвэр сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн нь тогтоогдоогүй бол тамирчны зөвшөөрлөөр тухайн зөрчилийг олон нийтэд тунхаглана. 14.3.2-р хэсгийг харна уу.

СПОРТЫН БАГИЙН ТӨРЛҮҮД

Хэрвээ Та спортын багийн төрөлд ордог ба сэргээш хэрэглэсэн нь тогтоогдвол Танд Хуулийн бүх заалтууд хэрэгжигдэнэ. Үүнээс гадна үүнээс үүдэн гарсан бүх үр дагаврууд нь Таны багт нөлөөлнө. Танай баг орж байгаа спортын арга хэмжээний зохион байгуулагчид Танай багт тавигдах хориг арга хэмжээ ноогдоно. 11-р хэсгийг харна уу.

ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

Сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөнтэй холбоотой тухайн үйл ажиллагаа нь сэргээшийн эсрэг дүрмийг зөрчсөн байж болох огноогоос арван жилийн дотор хүчинтэй.

ХЭРЭГ СОНСОХ БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ

Бүх тамирчид хараат бус байгууллагын өмнө шударга ёсоор хэргээ сонордуулах эрхтэй. Мөн цаг тухайд нь тэдгээрийн хэргийг сонсох эрхтэй.

Хэрвээ Таны хэрэг олон улсын үйл явдалд оролцсонтой холбоотой эсвэл хэрвээ Та олон улсын түвшний тамирчин бол Та болон бусад Сэргээшийн эсрэг Байгууллага нь зөвхөн Спортын Арбитрын шүүхэд гаргасан шийдвэрт давж заалдаж болно. Бусад тохиолдолд тухайн шийдвэрийг хараат бус шударга үндэсний байгууллагад давж заалдаж болно. 13-р хэсгийг харна уу.

10-р ХЭСЭГ. ИРЭЭДҮЙ РҮҮ БУЦАХ

2015 оны Хуульд шинэ өөрчилөлтүүдийг оруулж байна. Хууль нь цэвэр тамирчдыг дэмжин дэлхийн тамирчдад мөн дийлэнх тамирчдад цэвэр спортын төлөө сонголт хийх шинэ боломж олгож байна.

Танай улс орон эсвэл танай спортын төрөлд хамааралтай нэмэлт мэдээлэл авахын тулд өөрийн орны спортын холбоо эсвэл үндэсний сэргээшийн эсрэг байгууллагатай холбогдоно уу.

Боловсролын болон Мэдээллийн хөтөлбөрийн тухай илүү ихийг мэдэхийг хүсвэл ОУСЭА-ийн сайт руу орно уу.

Хавсралтууд

1-р ХАВСРАЛТ. СЭРГЭЭШ-ХЯНАЛТЫН ЖУРАМ.

СЭРГЭЭШ ХЯНАЛТЫН ЖУРМЫН 11 АЛХАМ

Тухайн хавсралт нь шээсний дээжийг сонгох журмыг тодорхойлоход зориулагдсан болно.

Тухайн хавсралтын хамгийн сүүлд нь насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад зориулсан онцгой бага зэргийн өөрчлөлттэй танилцаж болохыг мэдээлж байна.

Илүү тодорхой мэдээлэлийг ОУСЭА-ийн сайт, Үндэсний сэргээшийн эсрэг байгууллага болон олон улсын холбооноос үзэж болно.

Юуны түрүүнд дээжийн бүрэн бүтэн байдал нь түлхүүр цэг гэдгийг тодотгож өгөх хэрэгтэй. Дээжийн бүрэн бүтэн байдал алдагдаагүй ба тухайн журмаас хазайсан бол сорилын үр дүнг хүчингүйд тооцохгүй байж болно.

1. ТАМИРЧДЫГ СОНГОХ

Аль ч цаг хугацаанд, ямар ч газарт Таныг сэргээш-хяналтанд орохоор сонгоно.

2. МЭДЭГДЭЛ

Сэргээш-хяналтын байцаагч (цаашид СХБ) Таныг сэргээш-хяналтанд орохоор сонгосон тухай мэдэгдэнэ. СХБ нь Таны эрх, үүргийг мэдээлнэ. Тухайн үйл ажиллагааны үед төлөөлөгч байлгах эрхтэй.

Таныг сэргээш-хяналтанд орохоор сонгогдсоныг батлах зааварт гарын үсэг зурахыг хүснэ.

3. СЭРГЭЭШ-ХЯНАЛТЫН СТАНЦИД ОЧИХ

Та сэргээш-хяналтын пунктэд цаг алдалгүй очих ёстой.

СХБ нь бэлтгэл дуустал эсвэл хэвлэлийн бага хурал зэрэг шалтгаанаар сэргээш-хяналтын пунктэд ирэхийг хойшлуулах тал дээр зөвшөөрч болно.

Таныг сэргээш-хяналтанд орох шаардлагатайг мэдээлсэн цагаас СХБ нь сэргээш-хяналтын үйл явц дуустал Таныг дагалдана.

4. ЭЗЭЛХҮҮНИЙГ СОНГОХ

Танд дээжийг цуглуулах үзэлхүүнийг сонгох боломж олгоно. Та нэг эзэлхүүнийг сонгож болно.

Та тоног төхөөрөмж нь эвдрээгүй эсвэл хуурамчаар үйлдээгүй гэдгийг шалгах хэрэгтэй. Тухайн цаг хугацаанд Та өөрийн эзэлхүүнээ харагдахуйц газар байрлуулсан байна.

5. ДЭЭЖИЙГ ӨГӨХ

Дээж өгөх үед тантай нэг хүйстэй хүнийг СХБ нь ариун цэврийн өрөөнд байхыг зөвшөөрнө.

Таныг гараа угаахыг хүснэ.

Үүний дараа СХБ нь шээс өгөх үйл ажиллагааг саадгүй харахын тулд Таныг өөрийн хувцсаа өргөх эсвэл буулгахыг хүснэ.

6. ШЭЭСНИЙ ХЭМЖЭЭ

СХБ нь Таныг байхад хамгийн бага шаардлагатай шээсний хэмжээг өгсөн гэдгийг шалгана: 90 мл. Хэрвээ Та эхний оролдлогоор 90 мл шээс өгч чадаагүй бол шаардлагатай хэмжээ болох хүртэл дахин өгөхийг хүснэ.

7. ДЭЭЖИЙГ ХУВААХ

Танд дээжийг хадгалах болон тээвэрлэх санал болгож байгаа иж бүрдэлийг сонгох боломж олгоно Нэг иж бүрдэлийг гэмтсэн эсвэл орлуулан хийсэн эсэхийг шалгах ёстой. Шил савыг онгойлгоно уу. Шилэн дээр байгаа дээжийн дугаар нь таг болон саван дээр байгаа дугаартай таарч байгааг шалгана.

Дараа нь дээжийг В саванд хамгийн багаар 30 мл, үлдсэн хэсгийг А саванд хувааж хийнэ.

Таныг шээсний багахан хэмжээг үлдээхийг хүснэ, учир нь СХБ нь Таны шээсний нягтралыг хэмжих шаардлагатай. Үүний тулд хэрвээ Танд тусламж хэрэггүй бол шээсийг өөрөө хэмжих хэрэгсэлд тусаана. Хэрвээ тусламж хэрэгтэй бол Таны төлөөлөгч эсвэл СХБ нь таны өмнөөс шээсийг тань тусаахыг зөвшөөрнө.

8. ДЭЭЖИЙГ БИТҮҮМЖЛЭХ

Дараа нь А болон В шилийг битүүмжилнэ. (эсвэл Таны төлөөлөгч). Та болон СХБ нь шилийг зохих ёсоор битүүмжилсэн эсэхийг шалгана.

9. ШЭЭСНИЙ НЯГТРАЛЫГ ХЭМЖИХ

СБД шээсний нягтралыг хэмжих ёстой. Хэрвээ нягтрал нь стандартад зохицохгүй бол Та өөр дээжийг өгөх шаардлагатай.

10. СЭРГЭЭШ ХЯНАЛТЫН ПРОТОКОЛЫГ БӨГЛӨХ

Протоколд Та бүх эмнүүдийг заах шаардлагатай- жороор эсвэл жоргүйгээр авсан эсвэл сүүлийн хугацаанд ууж байсан хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд зэрэг.

Мөн протоколд Та сэргээш хяналтын үйл явцын дурын хэсэгт ямарваа нэгэн сануулгыг зааж болно.

Мөн Танаас сэргээш хяналтын зорилгоор шинжилгээ дууссаны дараа Таны дээжийг нэргүйгээр судлаж болох тухай зөвшөөрөл авна. Та “зөвшөөрч байна” эсвэл “үгүй” гэсэн хариулт өгнө.

Протоколыг ялангуяа дээжийн дугаарыг сайтар анхааралтай шалгаарай.

Мөн лабораторт зориулсан протоколын хуулбар нь Таныг тодорхойлж болох ямар ч мэдээлэл агуулаагүй байгааг шалгаж үзээрэй.

Таныг протоколд гарын үсэг зурахыг хүсэмжилнэ.

Үйл явц дууссаны дараа сэргээш хяналтын протоколын хуулбар хувийг авна.

11. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ

Таны дээж аюулгүй аргаар тээвэрлэхэд зориулагдан баглагдсан байна. ОУСЭА-ын магадлан итгэмжлэгдсэн лаборатори руу явуулна. Таны дээжийг судлах явцад тухайн лаборатори нь хамгаалалтын гинжийг мөрдөн лабораторид зориулагдсан Олон улсын Стандартыг дагаж мөрдөнө.

Таны А дээжийн шинжилгээ хийгдэнэ.

Таны В дээж аюулгүй байдалд хадгалагдана. Тухайн дээж нь А дээжийн шинжилгээний таатай бус үр дүнг батлахад ашиглана.

Цусны дээж гэж юу вэ ?

Шээсний дээж өгөхөд хэрэглэгдсэн адилхан нөхцөлийг мэдэгдэл өгөх, хувь хүнийг батлах, тус үйл явцыг дагалдах болон тайлбарлахад зориулан цуны дээж өгөхөд хэрэглэнэ.

Насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад зориулсан ямар онцлогууд байдаг вэ ?

МЭДЭГДЭЛ

Хэрвээ Та насанд хүрээгүй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй тамирчин ба Таныг сэргээш хяналтанд зориулан сонгосон тухай мэдэгдсэн бол энэ тухай гуравдагч талд мөн мэдэгдэж болно.

А ДЭЭЖИЙГ ӨГӨХ

Насан хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй тамирчид үйл явцад өөрийн төлөөлөгч нартай хамт байж болно. Гэвч тухайн төлөөлөгчид дээж өгөх процесст хамт байхыг зөвшөөрөхгүй. Яагаад ? Зорилго нь – шээс өгөх үйл явцад СХБ саадгүйгээр хяналт тавих явдал юм.

Хэрвээ Та төлөөлөгч байлгахгүйгээр шийдсэн бол Танай Сэргээшийн эсрэг Байгууллага эсвэл СХБ гуравдагч талыг байлгахыг хүснэ.

Хэрвээ хөдөлгөөний хязгаарлалттай эсвэл тэргэнцэртэй бол тамирчны төлөөлөгч эсвэл СХБ-ийг сэргээш хяналтын тоног төхөөрөмжтэй ажиллахад, дээжийг хуваах эсвэл бичгүүдийг бүрдүүлэхэд Танд туслахыг хүсэж болно.

Хэрвээ Та хөдөлгөөний зохицуулалтаа хийж чаддагүй бол дээжийг өгөхийн тулд том хэмжээтэй эзэлхүүнийг хэрэглэж болно.

Хэрвээ Та харааны асуудалтай бол тамирчны төлөөлөгч нь ариун цэврийн өрөөнд байхаас бусад сэргээш хяналтын бүх үйл ажиллагаа дуустал Таныг дагалдана. Гэвч төлөөлөгч шээс өгөх үйл явцад байж болохгүй. Тамирчны төлөөлөгч эсвэл СХБ нь Танд сэргээш хяналтын протоколыг уншиж өгөх ба Та тамирчны төлөөлөгчийг Таны нэрийн өмнөөс протоколд гарын үсэг зурж өгөхийг хүсэж болно.

Хэрвээ Та резинэн зайлуулагч эсвэл тогтмол катетер хэрэглэдэг бол Та тухайн шээс авагчаа шинэ шээс гаргаж авахад дөхөм хэлбэрээр гоожуулна.

Хэрвээ Та катетраа өөрөө хийдэг бол өөрийн катетраа шээсийн дээж өгөхдөө ашиглана. Тухайн катетр нь нээх хянагчаар хангагдсан байна. Эсвэл боломжтой бол СХБ-ийн олгосон катетрийг хэрэглэнэ.

Тамирчны төлөөлөгч оюун ухааны сааталтай тамирчныг сэргээш-хяналтын үйл явцын турш дагалдана. Гэвч төлөөлөгч шээс өгөх шууд үйл явцад байж болохгүй.



2-р ХАВСРАЛТ. В ДЭЭЖИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ

Лаборатори нь дээжийг тамирчны нэрээр биш дугаараар нь шинжилдэг. А дээжийг шинжилдэг лаборатори нь дээжийн үр дүнг ОУСЭА болон зохих ёсны сэргээшийн эсрэг байгууллага руу нэгэн зэрэг мэдээлдэг.

ШИНЖИЛГЭЭНИЙ ТААТАЙ БУС ҮР ДҮН

Хэрвээ А дээжийн судалгааны үр дүн эерэг үр дүн Хуулийн хэлээр- “Шинжилгээний таатай бус үр дүн” өгсөн тохиолдолд үр дүнгийн удирдлагад хариуцлага хүлээдэг байгууллага нь анхны шалгалтыг явуулна.

Ийм шалгалт нь 2 хэсгээс бүрдэнэ:

1. Таны дээжинд илэрсэн хориотой бодисыг эмчилгээнд хэрэглэх зөвшөөрөл авсан байсан эсэх,
2. Тогтоосон журмын дагуу сэргээш хяналтын үйл явц болон дээжийн хяналтын шинжилгээ хийгдсэн эсэх ?

Таны дээжийн судалгааны үр дүнгийн тухай болон В дээжийн хувьд Таны эрхийн тухай бичгээр мэдэгдэнэ.

Хэрвээ Та В дээжийн шинжилгээг хийлгэхийг хүсэж Сэргээшийн эсрэг байгууллага В дээжийн шинжилгээ авах шийдвэр гаргавал Та тухайн үед байж болох эсвэл өөрийн төлөөлөгчөө байлгаж болно.


Хэрвээ онцгой бодист хамаардаггүй хориотой бодис эсвэл хориотой арга А дээжийн шинжилгээний таатай бус үр дүн гарсан бол түр зуур түдгэлзүүлнэ. Хэрвээ Та түр зуур түдгэлзүүлэх болсон шалтгаанаар хэргээ шийдвэрлүүлэх эрхээ эдлэхээр шийдсэн бол Хууль Танд тухайн эрхийг эдлүүлнэ.

Эдгээр боломжууд нь тодорхой байдалд хугацаанаас хамаарна.

Хэрвээ В дээж нь А дээжийн шинжилгээний үр дүнг батлахгүй бол цааашид ямар ч үйлдэл хийгдэхгүй ба ямар ч түр зуурын түдгэлзүүлэлт цуцлагдана.

The official texts of the Athlete Reference Guide are the English and French versions maintained by the World Anti-Doping Agency and published on its website. The English version shall prevail in the event of any conflict of interpretation.

The World Anti-Doping Agency (WADA) wishes to acknowledge and thank the Central Asia Regional Anti-Doping Organization for their valuable contribution in the development of the Mongolian version of the Athlete Reference Guide. This enables the Athlete Reference Guide to be shared across countries globally so that WADA, the Public Authorities and the Sports Movement can work together to protect clean athletes.



With the support of



OLYMPIC
SOLIDARITY